

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/29/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Говь-Алтай аймаг Алтай хот 2021 он	Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Цэцэгмаа Утас: 99488754 Цахим хаяг: tsetsegmaab@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Төлбөрийн акт	16
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022. 02. 25 № 113

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Татварын тодорхойлолтоор авлагатай, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй 78.8 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ГААДАМБА ТАНАА

07020221

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х ТҮВШИНБАЯР



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	55,276,964.17	83,125,853.05
33	АВЛАГА	9,200,646.12	28,747,835.00
33500	Бусад авлага	9,200,646.12	28,747,835.00
33510	Байгууллагаас авах авлага	719,993.12	0.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	8,480,653.00	28,747,835.00
35	БАРАА МАТЕРИАЛ	46,076,318.05	54,378,018.05
35100	Түүхий эд материал	1,765,000.00	2,009,200.00
35110	Тусгай зориулалттай материал	1,765,000.00	2,009,200.00
35400	Хангамжийн материал	44,311,318.05	52,368,818.05
35410	Бичиг хэргийн материал	5,296,100.00	5,193,500.00
35420	Аж ахуйн материал	13,505,500.00	17,650,600.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,379,000.00	6,644,000.00
35470	Бусад хангамжийн материал	22,130,718.05	22,880,718.05
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	545,816,667.28	507,517,389.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	545,816,667.28	507,517,389.20
39200	Биет хөрөнгө	533,696,667.28	495,397,389.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	356,145,100.00	356,145,100.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-18,496,568.76	-29,626,103.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	225,291,750.00	225,291,750.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-100,761,750.00	-125,121,750.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	340,305,221.50	364,075,889.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-283,285,122.38	-304,639,462.21
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,685,592.88	52,180,592.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	-38,710,681.04	-43,871,752.97
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,450,000.00	26,450,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-24,926,874.92	-25,486,874.84
39300	Биет бус хөрөнгө	12,120,000.00	12,120,000.00
39301	Програм хангамж	1,730,000.00	1,730,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,730,000.00	-1,730,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12,120,000.00	12,120,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	601,093,631.45	590,643,242.25
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	601,093,631.45	590,643,242.25
51	Засгийн газрын хувь оролцоо	601,093,631.45	590,643,242.25
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	183,725,804.35	183,725,804.35
51200	Хуримтлагдсан үр дүн	413,609,111.92	403,158,722.72
51210	Өмнөх үеийн үр дүн	294,376,406.00	413,609,111.92
51220	Тайлант үеийн үр дүн	119,232,705.92	-10,450,389.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,758,715.18	3,758,715.18
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	601,093,631.45	590,643,242.25

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	815,776,410.10	762,502,997.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	80,699,685.00	89,043,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	80,699,685.00	89,043,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	80,699,685.00	89,043,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	79,369,685.00	86,004,032.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,330,000.00	3,039,868.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	735,076,725.10	673,459,097.12
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	499,968,100.00	499,904,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	499,968,100.00	499,904,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	204,891,798.40	149,426,197.12
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,300,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	179,591,798.40	149,426,197.12
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,606,700.00	22,606,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,606,700.00	22,606,700.00
1330	Төсвийн захирагчдаас	7,610,126.70	1,521,500.00
133003	Хөрөнгийн	7,610,126.70	1,521,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	696,543,704.18	772,953,386.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	696,543,704.18	772,953,386.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	559,405,940.19	566,614,927.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	362,317,888.76	352,902,759.74
210101	Үндсэн цалин	269,526,574.76	260,756,381.43
210102	Нэмэгдэл	68,711,897.00	65,091,999.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,526,135.00	10,951,099.40
210104	Урамшуулал	12,046,282.00	3,219,479.11
210105	Гэрээт ажлын хөлс	2,507,000.00	12,883,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,097,261.62	49,631,438.08
210201	Тэтгэврийн даатгал	32,664,561.62	35,199,038.08
210202	Тэтгэмжийн даатгал	3,608,200.00	3,608,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,886,600.00	2,886,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	721,700.00	721,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,216,200.00	7,216,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,598,845.91	18,155,139.33
210301	Гэрэл, цахилгаан	2,482,454.91	1,823,917.53
210302	Түлш, халаалт	15,681,824.00	15,585,155.80
210303	Цэвэр, бохир ус	2,434,567.00	746,066.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,957,916.70	30,205,023.64
210401	Бичиг хэрэг	11,333,616.70	11,088,150.00
210402	Тээвэр, шатахуун	16,495,600.00	15,348,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	361,000.00	617,423.64
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	150,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,767,700.00	3,001,400.00
2105	Нормативт зардал	494,700.00	199,900.00
210502	Хоол, хүнс	98,700.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,000.00	199,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,220,150.00	25,069,400.00
210604	Урсгал засвар	7,220,150.00	25,069,400.00
2107	Томилот, зочны зардал	15,811,200.00	14,745,797.00
210702	Дотоод албан томилот	15,811,200.00	13,943,197.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	802,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,128,458.00	2,334,988.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,060,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,691,200.00	1,483,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	146,258.00	93,738.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00

Говь-Алтай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	88,000.00	590,100.00
210807	Газрын төлбөр	121,000.00	145,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,779,519.20	73,370,482.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,056,369.00	10,495,436.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	310,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,723,150.20	62,564,946.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	137,137,763.99	206,338,458.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,728,900.00	38,237,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	27,862,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,728,900.00	10,375,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	79,369,685.00	86,004,032.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	79,369,685.00	86,004,032.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	31,524,542.83	76,880,370.51
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,007,854.09	4,451,560.67
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	29,516,688.74	72,428,809.84
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,514,636.16	5,216,955.94
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,514,636.16	5,216,955.94
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	119,232,705.92	-10,450,389.20
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	119,232,705.92	-10,450,389.20

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	183,725,804.35	3,758,715.18	300,790,430.00	488,274,949.53
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-6,414,024.00	-6,414,024.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	183,725,804.35	3,758,715.18	294,376,406.00	481,860,925.53
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	119,232,705.92	119,232,705.92
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	183,725,804.35	3,758,715.18	413,609,111.92	601,093,631.45
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	183,725,804.35	3,758,715.18	413,609,111.92	601,093,631.45
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	183,725,804.35	3,758,715.18	413,609,111.92	601,093,631.45
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-10,450,389.20	-10,450,389.20
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	183,725,804.35	3,758,715.18	403,158,722.72	590,643,242.25

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

				/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН		
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	806,836,283.40	757,941,629.12		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,369,685.00	86,004,032.00		
120	Нийтлэг татварын бус орлого	79,369,685.00	86,004,032.00		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	79,369,685.00	86,004,032.00		
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	79,369,685.00	86,004,032.00		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	727,466,598.40	671,937,597.12		
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	499,968,100.00	499,904,700.00		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	499,968,100.00	499,904,700.00		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	204,891,798.40	149,426,197.12		
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,300,000.00	0.00		
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	179,591,798.40	149,426,197.12		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,606,700.00	22,606,700.00		
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,606,700.00	22,606,700.00		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	658,374,283.40	736,715,829.12		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	658,374,283.40	736,715,829.12		
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	521,236,519.41	530,377,370.67		
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	370,798,541.76	373,169,941.74		
210101	Үндсэн цалин	278,007,227.76	281,023,563.43		
210102	Нэмэгдэл	68,711,897.00	65,091,999.80		
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,526,135.00	10,951,099.40		
210104	Урамшуулал	12,046,282.00	3,219,479.11		
210105	Гэрээт ажлын хөлс	2,507,000.00	12,883,800.00		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,817,254.74	48,911,444.96		
210201	Тэтгэврийн даатгал	33,384,554.74	34,479,044.96		
210202	Тэтгэмжийн даатгал	3,608,200.00	3,608,100.00		
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,886,600.00	2,886,500.00		
210204	Ажилгүйдлийн даатгал	721,700.00	721,600.00		
210205	Эрүүл мэндийн даатгал	7,216,200.00	7,216,200.00		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,598,845.91	18,155,139.33		
210301	Гэрэл, цахилгаан	2,482,454.91	1,823,917.53		
210302	Түлш, халаалт	15,681,824.00	15,585,155.80		
210303	Цэвэр, бохир ус	2,434,567.00	746,066.00		
2104	Хангамж, бараа материалын зардал	25,132,000.00	29,298,323.64		
210401	Бичиг хэрэг	6,229,300.00	9,686,750.00		
210402	Тээвэр, шатахуун	16,495,600.00	15,348,050.00		
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	361,000.00	617,423.64		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	150,000.00		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,046,100.00	3,496,100.00		
2105	Нормативт зардал	494,700.00	395,900.00		
210502	Хоол, хүнс	98,700.00	0.00		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,000.00	395,900.00		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,833,850.00	28,857,000.00		
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	917,000.00		
210602	Тавилга	208,000.00	61,000.00		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	450,000.00		
210604	Урсгал засвар	9,625,850.00	27,429,000.00		
2107	Томилолт, зочны зардал	15,811,200.00	14,793,197.00		
210702	Дотоод албан томилолт	15,811,200.00	13,943,197.00		

210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	850,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,428,458.00	2,384,988.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,060,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,691,200.00	1,483,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	146,258.00	93,738.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	388,000.00	640,100.00
210807	Газрын төлбөр	121,000.00	145,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,321,669.00	14,411,436.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,321,669.00	14,129,836.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	281,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	137,137,763.99	206,338,458.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,728,900.00	38,237,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,501,300.00	27,862,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,227,600.00	10,375,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	79,369,685.00	86,004,032.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	79,369,685.00	86,004,032.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	31,524,542.83	76,880,370.51
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,007,854.09	4,451,560.67
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	29,516,688.74	72,428,809.84
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,514,636.16	5,216,955.94
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,514,636.16	5,216,955.94
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	148,462,000.00	21,225,800.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	148,462,000.00	21,225,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	148,462,000.00	21,225,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	148,462,000.00	21,225,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	148,462,000.00	21,225,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-148,462,000.00	-21,225,800.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

			/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	522,511,400.00	512,842,883.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	522,511,400.00	512,842,883.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	484,209,300.00	474,605,783.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	364,810,900.00	364,030,378.29
210101	Үндсэн цалин	271,884,000.00	271,883,999.98
210102	Нэмэгдэл	65,092,000.00	65,091,999.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,951,100.00	10,951,099.40
210104	Урамшуулал	4,000,000.00	3,219,479.11
210105	Гэрээт ажлын хөлс	12,883,800.00	12,883,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,209,500.00	47,525,444.96
210201	Тэтгэврийн даатгал	34,777,100.00	33,093,044.96
210202	Тэтгэмжийн даатгал	3,608,100.00	3,608,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,886,500.00	2,886,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	721,600.00	721,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,216,200.00	7,216,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,606,700.00	18,155,139.33
210301	Гэрэл, цахилгаан	2,782,100.00	1,823,917.53
210302	Түлш, халаалт	18,390,000.00	15,585,155.80
210303	Цэвэр, бохир ус	1,434,600.00	746,066.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,531,000.00	14,530,999.81
210401	Бичиг хэрэг	6,229,300.00	6,504,900.00
210402	Тээвэр, шатахуун	5,644,600.00	5,456,848.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	361,000.00	273,151.81
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,296,100.00	2,296,100.00
2105	Нормативт зардал	396,000.00	395,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,000.00	395,900.00
2107	Томилолт, зочны зардал	16,336,800.00	13,943,197.00
210702	Дотоод албан томилолт	16,336,800.00	13,943,197.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,097,300.00	834,888.00
210803	Даатгалын үйлчилгээ	431,200.00	223,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,500.00	93,738.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,400.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	350,000.00
210807	Газрын төлбөр	145,200.00	145,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,221,100.00	15,189,836.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,221,100.00	15,189,836.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,302,100.00	38,237,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,302,100.00	38,237,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,862,100.00	27,862,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,440,000.00	10,375,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	522,511,400.00	512,842,883.39
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	499,904,700.00	499,904,700.00
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	499,904,700.00	494,687,744.06
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,606,700.00	18,155,139.33
320001	Орон нутгийн төсвөөс	22,606,700.00	18,155,139.33

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТАЙЛАНТ ОН / төгрөгөөр /
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	149,426,197.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	149,426,197.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	76,997,387.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,139,563.45
210101	Үндсэн цалин	9,139,563.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,386,000.00
210201	Тэтгэврийн даатгал	1,386,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,767,323.83
210401	Бичиг хэрэг	3,181,850.00
210402	Тээвэр, шатахуун	9,891,202.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	344,271.83
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,022,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,193,800.00
210602	Тавилга	8,950,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	450,000.00
210604	Урсгал засвар	27,429,000.00
2107	Томилолт, зочны зардал	850,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	850,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,550,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,260,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	290,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	281,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	281,600.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	72,428,809.84
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	149,426,197.12
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	149,426,197.12
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	149,426,197.12

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Цэцэгмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд барилга, хот байгуулалтын болон газрын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, барилга хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлээр хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, захиалагчийн үүрэг гүйцэтгэх мөн түүнчлэн аймгийн эдийн засаг, нийгмийн зорилтыг хот байгуулалт, төлөвлөлтийн бодлоготой уялдуулан хотын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын газрыг баталгаажуулах, газрын кадастр эрхлэх мэдээллийн сан байгуулж, нийтэд мэдээллийг чанартай, өндөр төвшинд хүргэх зорилготой байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал болох 697.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 13.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 11.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2 хувиар буюу 10.4 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд 86.0 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого, 499.9 сая төгрөгийн санхүүжилтийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 149.4 сая төгрөгийг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор, 22.6 сая төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг орон нутгийн төсвөөс тус тус бүрдүүлж оны эцэст үндсэн данснаасаа 4.4 сая төгрөгийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлж, үндсэн үйл ажиллагаанаас орсон 86.0 сая төгрөгийг Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газарт төвлөрүүлж, нэмэлт санхүүжилтийн данснаас 72.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн буюу 2021 оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 54.4 сая төгрөг болж 8.3 сая төгрөгөөр өссөн. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 50.8 сая төгрөгийн бараа материал худалдан авч 1.5 сая төгрөгийн бараа материал шилжүүлэн авч үйл ажиллагаандаа 44.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,037.9 сая төгрөг болж 24.2 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 24.3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 3.0 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авчээ. Тайлант онд үндсэн хөрөнгөд 62.5 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 590.6 сая төгрөг болж 10.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн хаасан бичилт хийгээгүй. Тайлант онд хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 403.1 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 573.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 50.5 сая төгрөгөөр буурч, 522.5 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс өндөр байгаа нь урсгал зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд газрын зураглал, кадастр хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг тусгай зориулалтын шилжүүлэг, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 522.5 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 499.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 22.6 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 512.8 сая төгрөгийг зарцуулж тусгай зориулалтын шилжүүлэг болох 5.2 сая төгрөгийг, орон нутгийн төсөвт 4.4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 512.8 сая төгрөг буюу 98.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 0.7 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 1.7 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4.4 сая төгрөгөөр, томилолт зочны зардлыг 2.4 сая төгрөгөөр, бусад зардлын бүлгийг зардлыг 0.3 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 149.4 сая төгрөгийн орлого хүлээн авсан төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого дансанд орлогыг тайлагнасан. Нэмэлт санхүүжилтийн орлогоос цалин хөлс болон түүнтэй адилтгах нэмэгдэл урамшлын зардалд 9.1 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 1.4 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 14.8 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 49.0 сая төгрөг, томилолт зочны зардалд 0.8 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардалд 1.5 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 0.3 сая төгрөгийг зарцуулж, 72.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг

санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Говь-Алтай аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар нь 2021 онд нийт 927.6 сая төгрөгийн 137 мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас 225.3 сая төгрөгийн 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2.4 сая төгрөгийн төлбөрийн акт 18.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг биелүүлсэн талаар албан бичиг нотлох баримт ирсэн байна. Шүүхийн шийдвэрээр олгосон нөхөн төлбөрийг барагдуулах заалттай албан бичгийн дагуу аймгийн Прокурорын газарт хандаж хамтран ажиллаж байгаа талаар ирүүлсэн албан бичигт нотлох баримт авагдсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Төрийн албаны зөвлөлийн шалгалтаар төрийн албаны тухай хууль зөрчиж томилогдсон 3 албан тушаалтны сонгон шалгаруулалт, тус орон тоонд ажиллаж байгаа албан хаагчийн талаар болон автомашины ашиглалт, төвлөрүүлбэл зохих газрын төлбөрийн авлагын барагдуулалтыг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 128.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 40.5 сая төгрөгийн алдааг залруулж, 0.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 86.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар тайлант онд 20.2 сая төгрөгийн худалдан авалтын гүйлгээ төлбөрийн баримтын нэгдсэн системийн баримтын жагсаалтын худалдан авалт төрөлд бүртгэгдээгүй байсныг аудитын хугацаанд нөхөн шивүүлж анхан шатны баримтын шаардлагыг хангуулж, урьд жилүүдэд олгосон 20.3 сая төгрөгийн цалингийн нөхөн олговрыг санхүүгийн тайланд авлагаар тусгуулж залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Шатахууны тооцоог давтан хийхэд 0.5 сая төгрөгийн шатахууныг анхан шатны баримтгүйгээр зарцуулснаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг

бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Тушаал шийдвэргүйгээр 0.4 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Татварын тодорхойлолтоор 77.9 сая төгрөгийн илүү төлөлттэй боловч санхүүгийн тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийг 10 хувиас доошгүй хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Зардлын эдийн засгийн ангилал зөрчин 8.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэсэн нь Сангийн сайдын 2021 оны "Зардлын эдийн засгийн ангилал батлах тухай" 190 дүгээр тушаал "210602 тавилга бичиг хэргийн ширээ, сандал, шүүгээ гэх мэт тавилга бэлтгэх зардал энд багтана" гэсэн заалттай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Шүүхийн шийдвэрээр олгосон П.Лхагвабаатарт олгосон 20.3 сая төгрөг, Б.Дулмаад олгосон 2.7 сая төгрөг нийт 23.0 сая төгрөгийн цалингийн нөхөн олговрыг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ." Хөдөлмөрийн тухай хуулийн 132.1-т "Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ." 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд 225.3 сая төгрөгийн 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай гэсэн заалтыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	/сая төгрөгөөр/									
		Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	9	128.3	2	40.5	2	0.9	4	86.9	1	